

## Оюу Толгойн талаарх нээлттэй мэтгэлцээний үеэр хөндөгдсөн асуудлууд ба бодит байдал

	Хэн	Юу хэлсэн	Бодит байдалд нийцэх эсэх	Оюу Толгой ХХК-ийн тайлбар/нэмэлт мэдээлэл
1	<b>С.Баярцогт:</b>	Оюутолгойн гэрээ Монгол улсад ямар ч эрсдэлгүй, Оюу Толгой бол Монгол улсад ашигтай гэрээ. Нийт орлогын 53 хувийг буюу өнөөгийн үнэ цэнээр нийт орлогын 59 хувийг Монгол улсад эзэмшиж байгаа.	Бодит	<i>Монголын тал татвар төлөгчдийн мөнгийг буюу улсын төсвөөс мөнгө гаргахгүйгээр Оюутолгой ХХК-ийн 34 хувийг эзэмшиж, мөн уурхайг ашиглалтад оруулах 6 тэрбум орчим ам.долларыг бэлэн мөнгөөр урьдчилан гаргаж хуваалцаж төлөхгүйгээрээ энэ гэрээ эрсдэлгүй юм. 34 хувийн эргэн төлбөрөөр зөвхөн ногдол ашгаасаа төлөх заалттай учир Оюу Толгой уурхай ашиггүй ажилласан ч Монголын талын эзэмшиж буй 34 хувийн төлбөрийг гадаадын хөрөнгө оруулагчид хариуцах юм.</i>
2	<b>С.Ганбаатар:</b>	Энэ гэрээ бол тааруу болсон гэдгийг дахин хэлье. Сая Баярцогт гишүүн маш чухал зүйл ярилаа. Ашгийн 53 хувийг Монголчууд авна гэж байна. Үүнийг задалж хэл. Бараа бүтээгдэхүүн, бэлтгэн нийлүүлэлтийн ашгийг оруулаагүй байх.	Ташаа	<i>Монгол улсын хувьд Оюу Толгой ХХК-ийн эзэмшил 34 хувийн хувьцааны ногдол ашгаасаа гадны хөрөнгө оруулагчдын зарцуулж буй хөрөнгөөс татвар, хураамж аваад зогсохгүй, байгалийн нөөц ашигласны төлбөр болон НӨАТ-ыг улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудаар дамжуулан авах юм. Энэ бүх хэлбэрээр Оюу Толгойгоос олох 100 ам.доллар тутмаас 71 нь Монголд үлдэх судалгааг Олон улсын валютын сан гаргасан бол уг тооцоог Монголын Засгийн газар 59 хувь гэж үзэж байгаа болно. Уг тооцоонд бэлтгэн нийлүүлэгчтэй зарцуулж буй мөнгөн урсгал буюу шууд бус ямар ч үр өгөөжийг оруулж тооцоогүй болно.</i>
3	<b>С.Баярцогт:</b>	Байгалийн баялаг 100% Монгол улсын Засгийн газрын мэдэлд байгаа. Төслийн санхүүжилт 100 хувь гаднаас орж ирж байна. Ашгийн хуваарилалтын хувьд 53 хувь нь Монголын талд, 47 хувь нь хөрөнгө оруулагчдын талд байна.	Үндэслэлтэй	<i>Монгол улс газар доорхи баялгаа 100 хувь эзэмшдэг. Уг баялгаа эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд гуравдагч хөршийн орнуудын хөрөнгө оруулагчтай хамтран Оюу Толгой ХХК-ийг байгуулсан бөгөөд тус компанийн 34 хувийн хувьцааг эзэмшдэг билээ. Олон улсын валютын сангийн 2010 оны судалгаанд Монгол улс Оюу Толгой төслийн нийт мөнгөн урсгалын 71 хүртэлх хувийг авах бололцоотой гэж үзсэн байна.</i>

4	<b>С.Ганбаатар:</b>	Ногдол ашиг дээр өнөөдөр уурхайгаас нэг кг зэс олборлоогүй байхдаа бид 3.1 тэрбум ам.долларын өртэй байгаа. Одоо өрөнд орчихсон бид нар.	Үндэслэлтэй	<i>Оюу Толгой ХХК-ийн 34 хувийг Монголын тал эзэмшиж байгаа бөгөөд уг бизнесийг бүтээн байгуулахад зарцуулах нийт зардлын 34 хувийн хөрөнгө оруулалтаа ямар ч эх үүсвэрээс оруулах боломжтой юм. Засгийн газар улсын төсвийн хөрөнгөөс санхүүжилтийг хийх, эсвэл гадаадын банкнаас зээл авч энэ уг 34 хувийг санхүүжүүлэх боломж нь хэзээд нээлттэй. Харин Засгийн газар 34 хувиа ногдол ашгаасаа төлөх нөхцөлтэйгөөр Хөрөнгө оруулагчдаас бага хувийн зээл авах замыг сонгосон. Гэхдээ хэзээ ч авсан зээлээ цуцалж, бэлэн мөнгө оруулж болно. Хөрөнгө оруулагчид Засгийн газарт зээл өгөх гээд байгаа бус, Засгийн газар энэ замыг сонгож авсан юм. Хэрэв Засгийн газар өөр эх үүсвэрээс 34 хувийн санхүүжилтээ гаргах шийдвэр гаргавал Хөрөнгө оруулагчдад илүү амар байх юм.</i>
5	<b>С.Ганбаатар:</b>	Энэ гэрээ хуулийн дагуу болоогүй. Товчхондоо энэ гэрээг хууль зөрчсөн гэж би үзэж байна.Энэ гэрээнд хууль давсан заалтууд байгаа. Хамгийн гол нь хууль ярихаасаа илүү Монголын иргэдэд ашигтай юу, үгүй юу гэдгийг л ярина.	Ташаа	<i>2001 оноос хойш гурван УИХ-аар хэлэлцэгдэж, Монгол Улсын Их Хурлаар батлагдаж, Засгийн Газрын баталгаажуулсан олон улсын хэмжээний гэрээ хэлэлцээр бол өөрөө хууль юм. Гэрээнд хууль зөрчсөн гэх үндэслэл байхгүй.</i>
6	<b>С.Ганбаатар:</b>	4 орчим тэрбум, 5.1 тэрбум гээд энэ олон зөрүүтэй тоонүүдыг яаж тайлбарлах юм бэ. ТЭЗҮ бол яг таг батлагдах ёстой байхгүй юу, та нар ТЭЗҮ-ийг батлаагүй.	Үндэслэлтэй	<i>Анхны хөрөнгө оруулалттай холбоотойгоор олон нийтийн дунд өөр өөр тооцоо байдаг тал дээр бид санал нэг байна. Оюутолгойн орд ашиглах техник эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг 2009 оны 7 дугаар сард Монгол улсын Эрдэс баялгийн зөвлөлд хүлээлгэн өгч, 2010 оны 3 дугаар сард Эрдэс баялаг, эрчим хүчний яамаар батлуулсан билээ. ТЭЗҮ-д 5,174 сая ам.доллар нь анхны хөрөнгө оруулалт буюу баяжуулах үйлдвэрийн ажиллагааг эхлүүлэхээс өмнө ил уурхайг байгуулах, хоногт 100,000 тонн хүдэр боловсруулах хүчин чадал бүхий баяжуулах үйлдвэр барих, гүний уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх, бусад дагалдах дэд бүтэц зэрэгт зарцуулахаар тодорхойлогдсон.</i>
7	<b>С.Баярцогт:</b>	НҮБ-ын гишүүн орны 50-60 улсын хүмүүс зэрэг ажиллаж байна	Ташаа	<i>Оюу Толгой төсөл дээр НҮБ-ын гишүүн 40 орны 15 мянган ажиллах хүч ажиллаж байна.</i>

8	<b>С.Ганбаатар:</b>	Бид ямар ч түвшинд тодорхойлогдоогүй. 14-р заалт дээр Рио Тинто гэдэг юм уу, Айванхоу Майнз, хөрөнгө оруулагчдын талыг өнөөдөр дандаа эрхийг нь баталгаажуулсан зүйлүүд байгаа. Нэгхэн заалт Монголын Засгийн газрын эрхийг баталгаажуулсан зүйл байдаг юм.	Ташаа	<i>Хөрөнгө оруулалтын гэрээнд Монголын Засгийн газар болон хөрөнгө оруулагчдын эрх үүргийг маш тодорхой заасан байгаа. Зөвхөн эрх ярих нь зохимжгүй, харин хөрөнгө оруулагчид нь Монголын бизнес, ажиллах хүчин, орон нутгийн хөгжил, дэд бүтэц, сургалт, байгаль орчны чиглэлээр олон үүргийг хүлээн түүнийгээ амжилттай хэрэгжүүлж байгаа билээ.</i>
9	<b>С.Баярцогт:</b>	Манай роялти тав, менежментийн зардал зургаан хувь гэж байна. Роялтиг нийт орлогоос авдаг, харин менежментийн төлбөрийг хоёр зардлын нийлбэрээр авдаг.	Бодит	<i>Менежментийн төлбөр уурхайн бүтээн байгуулалтын үед 3, харин үйлдвэрлэлийн шатанд 6 хувь байгааг Монголын талын авч буй роялти төлбөрөөс өндөр хувьтай байна гэж ярьдаг. Үнэн хэрэгтээ менежментийн төлбөрийг гарч буй үйл ажиллагааны зардал болон анхны хөрөнгө оруулалтын зардал хоёроос тооцож авдаг бол роялтиг нийт олж буй орлогоос авдаг. Ингэхээр хэдийгээр роялти хувь нь тооны хувьд бага ч авч буй эх нь нийт орлого байдаг учраас менежментийн төлбөрөөс хэд дахин өндөр байдаг.</i>
10	<b>С.Ганбаатар:</b>	Үндсэндээ энэ компани дотор бид хамтдаа байгаа мөртлөө эдний хооронд, энэ хөрөнгө оруулагч банк эсвэл санхүүжүүлэгчтэй байгуулж байгаа, мөн тоног төхөөрөмжөө түрээслүүлж байгаа энэ гэрээнүүд бидэнд ямар ч хамаагүй байгаа. Бид тойргын гадна гарчихсан, тэгэхлээр энэ гэрээ бидний эсрэг гэрээ болчихоод байна.	Ташаа	<i>Монголчууд Оюу Толгой төслийн тойргоос гарсан гэдэг нь үндэслэлгүй. Учир нь тус компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга нь, мөн удирдах зөвлөлийн гурван гишүүн нь Монгол хүн байгаа болно. Мөн арван мянга гаруй Монголчууд уг төслийг бүтээн байгуулалцаж байгаагийн дотор худалдан авалт хариуцсан, хүний нөөц хариуцсан, байгаль орчин хариуцсан олон чухал албыг Монгол хүмүүс хашиж байна. Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурснаас хойш Монголын ханган нийлүүлэгч компаниудаас 1 тэрбум ам.долларын бараа үйлчилгээ аваад байна. Хамгийн сүүлд гэхэд уурхайн ажилчдын хувцасны шүүгээ нийлүүлэх хагас сая долларын тендерт Монголын компани шалгарч, ажлаа эхлүүлээд байна.</i>

11	<b>С.Ганбаатар:</b>	Ингээд энэ бүхний тооцоог үзэхэд бид өөрсдөө 3.1 тэрбум ам.долларын өрөнд орчихсон.	Ташаа	<i>Монголын тал төслийн хугацаанд хэзээ ч өрөнд орохгүй, харин жинхэнэ өрийг хөрөнгө оруулагчид хариуцах юм. Хөрөнгө оруулагчид уурхайг барих хөрөнгө зарж байхад Монголын тал аль хэдийнэ 803 сая ам.долларын татвар хураамж, урьдчилгаа төлбөрийг хүлээн аваад байгаа билээ.</i>
12	<b>С.Ганбаатар:</b>	Лайбер дээр нэмэх нь 6.5-аар (судлаачид 7.6 гэж ярьж байгаа) тооцоход та 6.5-ыг хүүтэйгээр 6.5 тэрбум ам.долларыг өгнө.	Ташаа	<i>Лайбор нь зээш биш, харин зээлийн хүүгийн хэмжээг тодорхойлогч юм. Энэ нь арилжааны зээл олгогч байгууллагуудаас Засгийн газар авч болох зээлийн хүүгээс бага хэмжээтэй хүү юм. Хөрөнгө оруулагчид энэхүү зээлийн хүүг тогтоосноор Монголын талын мөнгийг хэмнэж чадсан билээ.</i>
13	<b>С.Баярцогт:</b>	Эргэж харах эрхзүйг зохицуулсан байгаа. 70 жилийн настай гэрээ учраас хоёр тал тохиролцвол бичгээр тохиролцоод гэрээнд өөрчлөлт оруулж болно гээд заачихсан байгаа.	Ташаа	<i>Оюу Толгойн уурхайг 70 ба түүнээс олон жилийн хугацаанд ашиглах боломжтой гэж үздэг ч Хөрөнгө оруулалтын гэрээг эхний 30 жилээр хийсэн бөгөөд 70 жил биш юм. Харин хоёр тал харилцан тохирч бичгээр баталгаажуулж гэрээнд өөрчлөлт оруулах бүрэн боломжтой.</i>

14	<b>С.Ганбаатар:</b>	Бид наймын 12-т заасан 90 хоногийн дотор Оюутолгойн сургалтын стратегийн төлөвлөгөө батал гэсэн. Өнөөдөр хүртэл гурилдсан цаас л байж байгаа. Тэрэн дотор нь бидний асуудаг юм гэвэл хэдэн Монгол хүнийг ямар техникийн ажил дээр ямар нөхцөл, цалинтай ажиллуулах юм бэл гэдэг.	Ташаа	<i>Оюу Толгойд олон монголчууд ажиллах ёстой. Энэ тал дээр Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн үүргээ Оюу Толгой ХХК биелүүлж байгаа. Үйлдвэрлэлийн шатанд 60 хувь Монголчууд, ашиглалтын үед 90 хувь Монголчуудаар ажиллах хүчээ бүрдүүлнэ гэж заасан. Одоогоор ашиглалтын үедээ хараахан ороогүй байгаа ч нийт ажиллах хүчний 81 хувь нь Монголчууд байгаа юм. Оюу Толгой компаний хэлтсүүдийн талаас илүү хувь нь 100 хувь Монголчуудаас бүрдсэн. 2010 оны 6 дугаар сарын 29-нд сэргэлтын стратеги төлөвлөгөөг Засгийн газарт өргөн барьсан. Үүний дагуу БСШУ-ны яамтай Санамж бичиг байгуулж хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.</i>
15	<b>С.Ганбаатар:</b>	Боловсон хүчин тал дээр муу, манай хүмүүсийг бэлдэхгүй байгаа.	Ташаа	<i>Оюу Толгой ХХК Монголын түүхэн дэх хамгийн том сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 168 тэрбум төгрөгийг зөвхөн уг сургалтын хөтөлбөрт зарцуулж байна. Налайх, Даланзадгад, Ханбогдод тус бүр нэг шинэ уул уурхайн жишиг сургууль барьж, Эрдэнэт, Дархан, Даланзадгад, Чойр дахь МСҮТ-ийг иж бүрэн шинэчлэн сайжруулах ажлыг гүйцэтгэж байна. Ханбогд дахь техник, мэргэжлийн сургалтын төв одоо ашиглалтад орсон, Налайх дахь сургалтын төвийн барилгын ажил явагдаж байгаа, Дархан хотын МСҮТ-ийг өргөтгөж, шинэчлэн сайжруулах ажил дууссан бөгөөд 2012 оны 12-р сарын 2-нд уг ажлыг хүлээлгэж өгнө. Эдгээр сургалтын төвүүдээс гадна Монгол улсын хэмжээнд 3300 мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажлыг Оюу Толгой гүйцэтгэж байна. Мөн МСҮТ-ийн 1200 багшийн мэргэжлийн ур чадварыг сайжруулахаас гадна гадаад, дотоодын их дээд сургуульд дээд боловсролын тэтгэлэгт хөтөлбөрт олон зуун оюутныг хамруулаад байна. Зөвхөн Өмнөговь аймгаас гэхэд 180 гаруй оюутан Оюу Толгой ХХК-ийн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан байна.</i>
16	<b>С.Ганбаатар:</b>	Тэгэхээр та Сэлэнгэ нутгийн хүн, Сэлэнгэ мөрөнг тийшээгээ урсгах эрхийг өгчихсөн байна л гэсэн үг шүү	Ташаа	<i>Сэлэнгэ мөрөн болон Монголын бусад гол горхийг Оюу Толгой төсөл рүү татах тухай заалт Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд байхгүй.</i>

17	<b>С.Ганбаатар:</b>	Хамгийн харамсалтай нь энд зэс хайлуулах үйлдвэр баригдахгүй. Зэс хайлуулах үйлдвэр барихаар болбол судалгааны тайланг гурван жилийн дотор боловсруулна гэж бас орсон байгаа.	Үндэслэлтэй	<i>Зэс хайгуулах үйлдвэр байгуулах тухай судалгааны ажлыг хамтран хийх тухай Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан, энэ хэвээрээ.</i>
18	<b>С.Баярцогт:</b>	Барилгын ажлын үед нийт ажилчдын 60 хувь нь Монгол хүн байх ёстой. Үйлдвэрлэлийн үед нийт ажилчдын 90 хувь нь Монгол хүн байх ёстой.	Бодит	<i>Оюу Толгой ХХК Хөрөнгө оруулалтын гэрээгээр хүлээсэн ажиллах хүчний талаархи үүргээ амжилттай биелүүлж байна. Оюу Толгой ХХК зөвхөн 2012 онд л гэхэд 1300 шинэ ажлын байр бий болгоод байна. Одоогоор компанийн Монгол ажилчид 88 хувь, харин нийт төслийн хувьд 81 хувь нь Монголын ажиллах хүч байгаа болно. Энэ нь бид үйлдвэрлэлийн үед 90 хувийн Монгол ажилчидтай болоход бэлтгэгдсэн байгааг илэрхийлж байна.</i>
19	<b>С.Ганбаатар:</b>	Татвар дээр ерөөсөө л Оюутолгой гэдэг улс манайд байгуулагдсантай л адилхан. Өнөөдөр бид татвараа доошоо болгох юм уу, өөрчлөх эрхгүй. Хэрвээ доошлуулбал Оюутолгой тэрийг ашиглана.	Ташаа	<i>Оюу Толгой төслийг хэрэгжүүлэх хугацаанд хөрөнгө оруулагчдыг татварын болон бизнесийн тогтвортой орчноор хангах үүргийг Засгийн газар хүлээсэн. Хөрөнгө оруулалтыг ийнхүү татаж чадсанаар Оюу Толгойн хөрөнгө оруулалтын гэрээ нь дэлхийн бусад хөрөнгө оруулагчдад итгэл найдварыг өгсөн жишиг гэрээ болсон. Тийм ч учраас 2009 оноос хойш Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ Оюу Толгой төслийн оруулахгүйгээр 13 дахин нэмэгдсэн юм.</i>
20	<b>С.Ганбаатар:</b>	Бид Монгол хүмүүсийг ажилтай болгоё, 50-60 жилийн дараа гадныхан гараад явахад өөрсдийн гэсэн боловсон хүчинтэй болчихоод дараагийн томоохон уул уурхайн орд, төслүүдээ хүний гар харахгүй хэрэгжүүлэе гэсэн бодлогоор явж байгаа учраас наймын ес бол үндсэндээ наймын дөрөв, таваа зөрчсөн байна.	Ташаа	<i>Оюу Толгойд олон мянган Монголчууд ажиллах ёстой. Энэ тал дээр Ганбаатар гишүүнтэй 100 хувь санал нэг байна. Харин Оюу Толгой ХХК 50-60 жилийн дараа биш 5-6 жилийн дотор Монголын боловсон хүчнийг бэхжүүлэх, уурхайг гардан гүйцэтгэх инженер, техникийн ажилчдыг бэлтгэж байна. Компанийн дотоодын сургалтын хөтөлбөрт өдгөө 400 гаруй уул уурхайн мэргэжилийн ажиллах хүчинг бэлтгэж, ажлын байраар хангаад байна. Оюу Толгойд зөвхөн ирээдүйд бус, яг одоо 11 мянга гаруй Монголчууд ажиллаж байгаа болно.</i>

21	<b>С.Баярцогт:</b>	Уул уурхай бүтээгдэхүүнээ гаргаж эхлээгүй байгаа байхгүй юу. Харин 2013 оны зургаа долдугаар сараас үйлдвэрлэл эхлэх юм бол жинхэнэ уул уурхайн эдийн засгийн үр дагаврууд орж ирнэ.	Үндэслэлтэй	<i>Оюу Толгой бүтээгдэхүүнээ энэ ондоо үйлдвэрлэж эхлэх ч 2013 оны дундуур зах зээлд гаргаж эхлэх юм.</i>
22	<b>С.Ганбаатар:</b>	Бид хөрөнгө оруулагч тал юм уу, зүгээр хамтрагч эсвэл ашиг хүртэгч тал юм уу	Үндэслэлтэй	<i>Монголын Засгийн газрыг төлөөлж Эрдэнэс Оюу Толгой ХХК нь Оюу Толгой ХХК-ийн хувь нийлүүлэгч. Засгийн газар нь хуульд заасан эрх үүргээ хэрэгжүүлдэг.</i>
23	<b>С.Ганбаатар:</b>	Хамаг мөнгө нь дандаа гадагшаагаа, гадаадаас орж ирсэн том том компаниудаар дамжаад гарчихдаг.	Ташаа	<i>Оюу Толгой ХХК 2010-2012 оны хооронд Монголын ханган нийлүүлэгч компаниудаас 1 тэрбум орчим ам.долларын бараа, үйлчилгээ худалдан аваад байна. Дэлхийн хамгийн том уурхайнуудын нэг болох Оюу Толгойд мэдээж уул уурхайн томоохон машин, техник худалдаж авахдаа олон улсын томоохон компаниудтай харилцах нь ойлгомжтой, гэхдээ гадаадаас авч буй бараа болгондоо улсад татвар төлж байгаа, дээр нь Монголоос авах боломжтой бүх бараа үйлчилгээг Монголоос авах тухай бодлого тус компанид мөрдөгдөж байна.</i>
24	<b>С.Баярцогт:</b>	Энэний дараа гаднаас орж ирж байгаа дотоодын нийт бүтээгдэхүүнд нөлөөлж байгаа нөлөөлөл нь 13 дахин ихсэж байгаа юм.	Үндэслэлтэй	<i>Оюу Толгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурснаас хойш буюу 2009 оноос хойш Монгол улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 13 дахин (Оюу Толгойг оролцуулахгүйгээр) нэмэгдсэн байна.</i>
25	<b>С.Ганбаатар:</b>	Менежментийн багийг төлөөлөн удирдах зөвлөл нь Айванхоу нь юм биш байгаа юм.	Ташаа	<i>Оюу Толгой төслийг Рио Тинто компани удирддаг бөгөөд удирдах зөвлөл нь Рио Тинто, Туркауз Хилл Ресурс, (хуучнаар Айванхоу Майнз) Эрдэнэс Оюу Толгой ХХК-н төлөөллөөс бүрдэнэ.</i>
26	<b>С.Ганбаатар:</b>	Цаагуур чинь Рио Тинто өөрсдөө зарлахдаа 7.8 тэрбум ам долларын анхын хөрөнгө оруулалт оруулна гэж байгаа.	Ташаа	<i>Оюу Толгойн төслийн анхны хөрөнгө оруулалтыг 6 орчим тэрбум ам.доллар гэж тооцож байгаа бөгөөд энэ нь 7.8 их наяд төгрөгтэй дүйцэх юм.</i>

27	<b>С.Баярцогт:</b>	Одоо нийт гэрээний хүчин төгөлдөр хэрэгжих 70 жилийн хугацаанд бид нар 118 тэрбум ам.долларын орлого олно	Ташаа	<i>2009 онд Монгол улсын Эрдэс баялгийн зөвлөлөөр баталгаажуулсан ТЭЗҮ-д Монголын тал нийт 36 тэрбум, хөрөнгө оруулагчид 32 тэрбум ам.доллар хүлээн авах тухай тооцоолсон байдаг. Гол анхаарах зүйл нь гэвэл Монголын тал богино хугацаанд энэхүү ашгаа авах боломжтой бол олон улсын хөрөнгө оруулагчид нэлээд сүүлд ашгаа авахаар байна. Бидний хэлдгээр маргаашийн өөхнөөс өнөөдрийн уушги дээр гэдэг шиг өнөөдрийн мөнгөний үнэ цэн 10 жилийн дараа олох мөнгөнөөс үнэтэй юм.</i>
28	<b>С.Ганбаатар:</b>	Энэ бол үндсэндээ 8 жил огт татвар авахгүй байна гэсэн үг.	Ташаа	<i>Монгол улс Оюу Толгой ХХК-иас татвар авдаг. Үүнийг Засгийн газар, Сангийн яам, Татварын Ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар болон орон нутгийн төсөвт байгууллагуудаас лавлаж болно. Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурснаас хойш Оюу Толгой ХХК 1 их наяд төгрөгийг татвар, хураамж, урьдчилгаа төлбөр хэлбэрээр улсын төсөвт төвлөрүүлсэн.</i>
29	<b>С.Баярцогт:</b>	Тиймээс хүмүүсийг богинго хугацаанд оруулж ирж хүмүүсээ сургаж байна. Үүнд зориулаад гурван ТМС байгуулж 300 сая төгрөгийн гаргаад үйл ажиллалгаа явуулж байна, гэрээ хийснээс хойш.	Ташаа	<i>Оюу Толгой ХХК Монголын ажиллах хүч бэлтгэх сургалтын хөтөлбөртөө 126 сая ам.доллар буюу 168 тэрбум төгрөг зарцуулж байгаа болно.</i>
30	<b>С.Ганбаатар:</b>	Гэрээнд өөрчлөлт оруулах боломжгүй, бүх зүйл хаалттай. Бичгээр л бие биедээ болж байна гэж хэлнэ үү гэхээс уулзах ч эрхгүй.	Ташаа	<i>Ямар ч гэрээ хэлцлийг бичгээр хийж баталгаажуулдаг учраас түүнд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол заавал бичгээр үйлдэх нь зүй ёсных, харин мэдээж өөрчлөх зүйлээ уулзаж, ярилцаж, тохиролцох нь ойлгомжтой.</i>

*Оюу Толгой хэвлэл, мэдээллийн алба  
2012 оны 11 дүгээр сарын 29н*